



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/181

Мандалговь

Малд үзлэг ангилалт, хянан
баталгаажуулалт хийх тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, ХХААХҮЯамны сайдын 2019 оны 4 дүгээр сарын 9-ны өдрийн А/102 тоот тушаал, Аймгийн засаг дарга, ХХААХҮЯ сайдтай 2019 онд хамтран ажиллах гэрээний 65 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өндөршил сумын “Өндөршил” адуу, Сайнцагаан сумын “Сайнцагаан” хонь, Хулд сумын “Олдохын хүрэн бор” тэмээн сүрэгт хавсралтад заасны дагуу үзлэг ангилалт хийж, хээлтүүлэгч шинээр нөхөн тавих, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг 2019 оны 5 дугаар сарын 8-наас 2019 оны 10 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулж тайланг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг холбогдох сумдын Засаг нарт даалгасугай.

Хоёр. Үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, хянан баталгаажуулалтын ажлыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



О.БАТЭРДЭНЭ

488190454

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дугаар сарын 08-ны өдрийн 9/184 тоот
захирамжийн хавсралт



НУТГИЙН МАЛ СҮРЭГТ ҮЗЛЭГ, АНГИЛАЛТАНД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО

№	Аймаг	Сум	Малын төрөл	Ангилалтанд хамрагдах мал		
				Нийт	Хээлтүүлэгч	Хээлтэгч
1	Дундговь	Өндөршил	Адуу	3000	100	2900
2		Сайнцагаан	Хонь	20000	300	19700
3		Хулд	Тэмээ	3000	30	2970
4		ЦСҮАА	Хонь	187		187
5			Ямаа	230		230
6	Нийт		Бог	20417	300	20117
7			Бод	6000	130	5870
8			Нийт	26417	430	25987